

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР, ОРЧНЫ
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ,
"УЛААНБААТАР МАРАФОН-2026" ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
ДАРГА

А.АМАРТҮВШИН

2026 оны 02 дугаар сарын 26

УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 02

Улаанбаатар хот

"УЛААНБААТАР МАРАФОН- 2026" ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг.Зорилго:

1.1.Эх орондоо гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өсвөр залуу үеийнхнийг өөрийн дотоод нөөц боломжоо нээх, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужилтай болгох, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил төлөвшүүлэхэд "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлт (цаашид "Марафон гүйлт" гэх)-ийн гол зорилго оршино.

1.2.Хамрах хүрээ: Ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн суралцагчид, нийслэл, дүүрэг, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагч, ажилтнууд, гадаад, дотоодын иргэд, мэргэжлийн гүйгчид

Хоёр.Марафон гүйлтийг зохион байгуулагчид:

2.1.Ерөнхий зохион байгуулагчид: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар

2.2.Хамтран зохион байгуулагчид: "Хай Пэй" ХХК, Монголын Хөнгөн атлетикийн холбоо

Гурав.Зохион байгуулах журам, хугацаа:

3.1."Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлт 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотын Д.Сүхбаатарын талбайд болно.

Тэмцээний зай, төрөл, насны ангилал:

№	Төрөл	Насны ангилал	Ангилал	Дагалдах зүйлс
1.	42 км	18+ нас	эм, эр	энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
2.		ХБИ 18+ нас	эм, эр	
3.	21 км	18-34	эм, эр	энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
		35-54	эм, эр	
		55+	эм, эр	
		ХБИ 18+ нас	эм, эр	
4.	10 км	18+ нас	эм, эр	энгэрийн дугаар, футболк, чип
5.		12-17	Охид, хөвгүүд	
6.	5 км	(Эрүүл мэндийн гүйлт) 18-аас дээш нас		энгэрийн дугаар

7.	1,5 км	Тэргэнцэртэй	эм, эр	энгэрийн дугаар
		Хараагүй	эм, эр	
8.	1,5 км	Гэр бүл	Гэр бүлээрээ хүний тоо харгалзахгүй	энгэрийн дугаар
9.	500м, 800м	Тусгай олимпын төрөл	Тусгай олимпын иргэд	энгэрийн дугаар

3.2."Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтийн нээлтийн ажиллагаа 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотын Д.Сүхбаатарын талбайд дараах хуваарийн дагуу болно.

08:30 цагт- Нээлт зохион байгуулна.

3.3.Марафон гүйлтийн гарааны цагийн хуваарь байрлал

- "А" буюу 1-р шугамд: Гараа: 09:00 цагт 42 км-ийн гүйлтэд оролцогчид;
- "В" буюу 2-р шугамд: Гараа: 09:00 цагт 21 км-ийн зайн гүйлтэд оролцогчид;
- "С" буюу 3-р шугамд: Гараа: 09:05 цагт 10 км-ийн зайн гүйлтэд оролцогчид;
- "D1" буюу 4-р шугамд: Гараа: 09:15 цагт 5 км-ийн 12-17 насны ангилалд оролцогчид;
- "D2" буюу 5-р шугамд: Гараа: 09:15 цагт 5 км-ийн 18-аас дээш нас, эрүүл мэндийн гүйлтийн ангилалд оролцогчид тус тус байрлан зогсоно. (Цуглах газар нь: Их сургуулийн гудамж Галлериа Улаанбаатар худалдааны төвийн урд талын буюу Засгийн газрын ордоны зүүн тал зам дээр гараа эхлэхээс 30 минутын өмнө зогссон байна.)

3.4.Гараа эхлэх хугацаа 09:00 цагт дохиогоор зайн тус бүр цагийн хуваарийн дагуу гүйлтүүд гараанаас гарна. Зай тус бүр тогтоосон маршрутаар гүйж Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

3.5.Бүтэн, хагас марафон буюу 42.195 км, 21.097.5 км-т оролцогчдын гүйлтийн үргэлжлэх хугацаа 5 цаг байх бөгөөд тухайн өдрийн 14:00 цагаар хязгаарлагдана.

3.6.Тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй иргэдийн зайн ангилалд оролцогчдын 1,5 км-ийн гараа 13:00 цагт, гэр бүлийн гүйлт 13:30 цагт тус бүр Монгол Улсын их сургуулийн нэгдүгээр байрны урд талын гарааны шугамаас гарч Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

3.7.Тусгай олимпын төрөлд оролцогчдын 500 м, 800 м-ийн гүйлтийг Монголын тусгай олимпын хорооны болон "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтийг зохион байгуулж буй Монголын хөнгөн атлетикийн холбооны шүүгчдийн бүрэлдэхүүн хамтран зохион байгуулна.

Тусгай олимпын төрөлд оролцогчдын гүйлтийн гараа нь 14:30-15:00 цагийн хооронд тусгай хөтөлбөрийн дагуу явагдана. Тус гүйлтийн 800 м-ийн зайн гүйлтийн гараа нь Спортын төв ордны баруун талын төв засмал зам, 500 м-ийн зайн гүйлтийн гараа нь Улаанбаатар зочид буудлын өмнөх төв засмал замын гарааны шугамаас гарч Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

3.8.Марафон гүйлтийн 42.195 км, 21.097.5 км, 10 км-ийн гүйлтэд оролцогчдын амжилтыг <https://ulaanbaatar.marathon.mn/> цахим хуудсанд байршуулна.

Бүх оролцогчид марафон гүйлтэд оролцсон "Батламж"-аа дээрх цахим хуудаснаас өөрсдөө хэвлэж авах боломжтой.

3.9.Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулагдах маршрутын хуваарилагдсан талбайд иргэдэд зориулсан урлаг, спорт, хүмүүнлэгийн арга хэмжээ зохион байгуулна.

Дөрөв. Бүртгэлийн ажиллагаа, хураамж:

4.1.Марафон гүйлтэд оролцогчид <https://ulaanbaatar.marathon.mn/> цахим хуудас болон hīpay аппликэйшнаар бүртгүүлж онлайнаар хураамжаа төлсөн байна.

4.2.Бүртгүүлсэн гүйгчид бүртгэлийн цэгт очиж энгэрийн дугаар авснаар гүйлтэд оролцох эрх нь баталгаажна.

4.3.Гүйлтэд оролцогчийн иргэний үнэмлэх, гадаад паспорт, төлбөрийг <https://ulaanbaatar.marathon.mn/> цахим хуудас, hīpay аппликэйшнаар хийсэн баримтыг үндэслэн энгэрийн дугаар олгож бүртгэл баталгаажсанаар гүйлтэд оролцох эрх нээгдэнэ.

4.4.Дотоод, гадаадын гүйгчдийн бүртгэлийн хураамжийн мэдээлэл

Гүйлтийн зай	1,5 км	5 км	10 км	21.097.5км	42.195 км
Төлбөр	5,000₮	10,000₮	50,000₮	70,000₮	90,000₮

Тусгай олимпын төрөлд оролцогчдын 500 м, 800 м-ийн гүйлтэд оролцогчид тухайн марафон гүйлтэд төлбөрийн хураамж төлөхгүй бүртгүүлж оролцоно.

4.5.Гүйгчдийн бүртгэлийн хураамж нь төсөвт төвлөрдөг тул сугалааны болон НӨАТ-ын баримт олгогдохгүй.

4.6.Марафон гүйлтийн бүртгэл 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулагдана.

4.7.Марафон гүйлтийн гэр бүл (1,5 км), 5 км-ийн зайд оролцогчийн энгэрийн дугаар олгох ажлыг дараах байршилд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 -17:00 цаг хүртэл зохион байгуулна.

- Нийслэлийн Биеийн тамир, спортын газар Утас:70002785;
- Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 70141983;
- Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 11450511;
- Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 70213435;
- Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 70491280;
- Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 70233601;
- Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 11344783;
- Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 11315651;
- Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 70176348;
- Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо Утас: 77773113;

4.8.Марафон гүйлтийн 42.195 км, 21.097.5 км, 10 км-ийн зайд оролцогчдын (гадаад, дотоодын иргэд) энгэрийн дугаар, чип, футболк олгох ажил 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд зохион байгуулагдана. Утас:70002785, 7766-7700 (hīpay)

4.9.Марафон гүйлтийн 5 км-ийн зай, 12-17 насны ангилалд 2009 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш төрсөн, 2014 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө төрсөн хүүхдүүд оролцоно.

4.10.Марафон гүйлтийн 1,5 км-ийн тэргэнцэртэй, хараагүй ангилалд зайд оролцогчдын баталгаажуулалт, энгэрийн дугаар олгох ажил Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулна.

4.11.Гэр бүлийн гүйлтийн 1,5 км-ийн зайд гэр бүлийн гишүүдийн тоо харгалзахгүй. Бүртгэлийг <https://ulaanbaatar.marathon.mn/> цахим хуудсаар бүртгэж энгэрийн дугаар олгож баталгаажуулна. Гүйлтэд оролцсон гэр бүлийн дурсгалын зургийг "Батламж"-ийн хамт олгоно.

4.12. "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтийн 500 м, 800 м зайн гүйлтэд тусгай олимпын харьяалалтай оролцогчид оролцох бөгөөд бүртгэлийг Монголын тусгай олимпын хороо хариуцаж гүйцэтгэнэ. Утас: (Мөнх-Од 80599948)

4.13. "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтийн энгэрийн дугаар аваагүй оролцогчдыг барианд барихгүй бөгөөд үзүүлсэн амжилт, хугацааг тодорхойлохгүй.

4.14. Бүртгэл, хураамжтай холбоотой мэдээллийг <https://ulaanbaatar.marathon.mn/sport.ub.gov.mn> цахим хуудас, hipay аппликэйшнаас авна. Утас: 70002785, 7766-7700 (hipay)

4.15. "Улаанбаатар марафон-2026" олон улсын тэмцээний бүх насны ангилалд оролцогчид эмчийн үзлэгт хамрагдан зүрхний цохилт, даралтаа хэмжүүлсэн байна. Хэвийн бус тохиолдолд гүйлтэд оролцохгүй ба оролцсон тохиолдолд хариуцлагаа хувь хүн өөрөө хүлээнэ.

4.16. "Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлтэд оролцогчдын байр, хоол, ирэх, буцах унаа болон бусад холбогдох зардлыг тэмцээнд оролцуулж байгаа тухайн байгууллага, хувь хүн хариуцна.

4.17. "Улаанбаатар марафон-2026" олон улсын тэмцээн зохион байгуулах өдөр буюу 2026 оны 05 дугаар сарын 23-ны 06:00 цагт гүйлтийн маршрутын дагуух авто замуудын орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах тул гүйлтэд оролцогчид тээврийн асуудлаа зохицуулж Д.Сүхбаатарын талбайд 08:00 цагаас өмнө ирж гарааны шугамд байраа эзэлсэн байна.

4.18. 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 07:00-07:30 цагийн хооронд хагас, бүтэн марафонд оролцогчдын тэжээлийг гараа гарах талбай дээр томилогдсон шүүгчид хүлээн авч тэжээлийн 2 цэгт байршуулна. Хоцорсон тохиолдолд хүлээн авахгүй. Тамирчид тэжээлийн сав дээр өөрсдийн энгэрийн дугаар, таних тэмдэглэгээ хийж хураалгана.

Тав. Шагнал урамшуулал:

5.1. Марафон гүйлтийн 42.195 км (18-аас дээш нас), 21.097.5 км (18-34 нас, 35-54 нас, 55-аас дээш) 10 км зайд эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй гүйгчдийг цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар, IV-X байр эзэлсэн гүйгчдийг өргөмжлөл, дурсгалын медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (харааны бэрхшээлтэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, саажилт, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэх мэт)-ийн (42.195 км, 21.097.5 км)-ийн гүйлтэд гүйж эхний I-III байрт шалгарсан тамирчдад цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар, IV-V байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

5.3. Марафон гүйлтийн 5 км-ийн зайд 12-17 насны эхний I-III байрт орсон охид, хөвгүүдийг цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар, IV-VIII байрт шалгарсан охид, хөвгүүдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

5.4. Марафон гүйлтийн 1,5 км-ийн тэргэнцэртэй, хараагүй ангилалд гүйж эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй гүйгчдийг цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

5.5. Марафон гүйлтийн 500 м, 800 м зайд тусгай олимпын төрөлд эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй гүйгчдийг цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.